

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
89 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Стандарт, хэмжил зүйн газар

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн
хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Аймаг дахь Стандарт хэмжил зүйн
хэлтэс

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд аймгийн хэмжээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах, хэмжил зүйн хяналт, шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хэмжил зүйн тухай хууль тогтоомж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал гаргах, тайлагнах;
- 2.Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтыг харьяа орон нутагт хийх;
- 3.Хяналтын шалгалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, эрсдэлийн үнэлгээ хийх;
- 4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан хэмжил зүйн болон хяналт шалгалттай холбогдолтой арга хэмжээг хэрэгжүүлэх;	Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд хэрэгжинэ.	Г
	2.Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хяналт шалгалттай холбогдолтой арга хэмжээг хэрэгжүүлэх;	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г
	3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалттай холбогдолтой арга хэмжээг хэрэгжүүлэх.	Төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Орон нутагт хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын баримт бичиг боловсруулах, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх;	Хяналт шалгалтын мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Г
	2.Хяналт шалгалтад хамрагдах объектын эрсдэлийн үнэлгээ хийж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тухайн жилд төлөвлөгөөт шалгалтад хамрагдах объектын талаар санал хүргүүлэх;	Хяналт шалгалтын төлөвлөлт хийгдсэн байна.	Г
	3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг орон нутагт зохио	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан	Г

	хууль, дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх;	байна.	
	4.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;	Хуулийн хэрэгжилтийг дээшлүүлсэн байна.	Г
	5.Цаг үеийн шаардлагатай уялдуулан олон нийт, иргэдийг эрсдэлээс хамгаалах хяналт шалгалтыг хийж үр дүнг тайлагнах.	Хяналт шалгалт үр дүнд хүрсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хэмжил зүйн хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, тайлагнах;	Бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Хариуцсан хяналтын чиглэлээр хийсэн шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрлүүлэх асуудлын талаар санал боловсруулж танилцуулах;	Салбарын хяналт шалгалтын үр дүн дээшилсэн байна.	Г
	3.Хэмжил зүйн салбарын хууль тогтоомж, дүрэм журам, техникийн зохицуулалт, стандарт болон эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгоход санал өгөх;	Санал боловсруулсан байна.	Г
	4.Хяналт шалгалтын дүнг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан удирдлагад танилцуулах;	Хяналт шалгалт үр дүнд хүрсэн байна.	Г
	5.Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, иргэд, бизнес эрхлэгчдийг мэдээлэл, зөвлөмжөөр хангах;	Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйлчилгээний соёл дээшилсэн байна.	Г



	6.Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд нэгжийн удирдлагатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, ажлаа 7 хоног, сар, хагас, бүтэн жилээр төлөвлөж, тайлагнан ажиллах;	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах;	Хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	Г
	3.Хэлтсийн үйл ажиллагааны зохион байгуулалтын ба ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх;	Ажлын гүйцэтгэл хангагдсан байна.	Г
	4.Байгууллагын үйл ажиллагаа болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах;	Хяналт шалгалтын талаар мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	Г, Т
	5.Байгууллагын болон салбарын сургалт зохион байгуулах удирдамж, төлөвлөлт, арга зүй, хөтөлбөр, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангаж, үр дүнг тооцох;	Хууль зүйн мэдлэг дээшилсэн байна.	Г
	6.Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	7.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгөх;	Хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	8.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
	9.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, авлига, ашиг сонирхлоос ангид байх;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
	10.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг цаг хугацаанд	Тухай бүрд тайлагнаж ажилласан байна.	Г

	нь тайлагнах.	
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - хэмжил зүйч; - инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /071/; - инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж /078/; - уул уурхайн олборлолт /0724/; - үйлдвэрлэл, боловсруулалтад ангилагдаагүй чиглэл /0729/; - байгалийн шинжлэх ухаан /053/. 	
Мэргэшил		
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно; - Улсын байцаагчаар эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх. 	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх чадвартай байх; - хариуцсан ажил, чиг үүрэгт хамааралтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; - дүн шинжилгээнд тулгуурлан авах арга хэмжээ, гаргах шийдвэрийг тодорхойлох, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хариу өгөх; - холбогдох асуудлаар хуульд нийцсэн, шийдвэрлүүлэх боломжтой санал, зөвлөмж гаргах; - удирдлагыг цаг үеэ олсон, шаардлагатай мэдээлэл судалгаагаар хангаж, зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
		<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, илгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;

	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олонтой соёлч боловсон, хүндэтгэлтэй харилцах, зохих мэдээлэл, зөвлөмж өгөх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвартай байх; - ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигладаг байх; - жендерийн тэгш байдлыг хангах; - бусад;


IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - зохион байгуулалтын бусад нэгж; - холбогдох төрийн байгууллага болон төрийн бус байгууллага; - орон нутгийн стандарт, хэмжил зүйн хэлтсүүд; - иргэн, хуулийн этгээд.
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
---	--

<u>Албан тушаал:</u> ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН БАЗРЫН ДАРГА  С.БАТБААТАР 202... Оны ... дугаар сарын ...-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 23 0407 <u>Дугаар:</u> 105
--	--

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр: СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА  БУУГАНБАЯР

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

